

ДеФакто **ТОЙМ**

УУХУЯ-НЫ ЗӨРЧИЛ

**БАНКУУДЫН АКТИВЫН
ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ**

**ДУЛААНЫ V ЦАХИЛГААН
СТАНЦ ТӨСЛИЙГ
ЗОГСООЛОО**

VI НҮҮРТ

ДеФакто **ЯРИЛЦЛАГА**

Б.ГЭРЭЛМАА

БЛОКЧЕЙН ТЕХНОЛОГИ НЬ

**ДЭЛХИЙ ДАЯАР ТАРХСАН,
ХАМГИЙН ӨНДӨР
НУУЦЛАЛТАЙ, ХАМГИЙН
ИХ ИТГЭЖ БОЛОХ ДЭД
БҮТЦИЙН ТЕХНОЛОГИ ЮМ**

IV НҮҮРТ

ДеФакто **НИЙТЛЭЛ**

Шатахууны үнийг

ХЭРЭГЛЭГЧ ТОГТООЁ

Монголын эдийн засгийн өнөөгийн дампуурлын суурь шалтгаан бол үнийг зах зээл биш засгийн газар тогтоож буй хэзээ ч, хаана ч үр дүнд хүргээгүй мунхаг, популист үйл ажиллагаа юм.

II НҮҮРТ

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

ЗОРИГЖУУЛНА

МЭДЭЛЖҮҮЛНЭ

Лхагва, 2018.01.17, №30

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХАРААТ БУС, БИЕ ДААСАН ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СОНИН

www.defacto.mn

Шатахууны үнийг

ХЭРЭГЛЭГЧ ТОГТООЁ





№ 414

Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**

Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>



Шатахууны үнийг

ХЭРЭГЛЭГЧ ТОГТООЁ

Монголын эдийн засгийн өнөөгийн дампуурлын суурь шалтгаан бол үнийг зах зээл биш засгийн газар тогтоож буй хэзээ ч, хаана ч үр дүнд хүргээгүй мунхаг, популист үйл ажиллагаа юм. Зах зээлийн эдийн засгийн агуулгыг ойлгоогүй, мэдлэггүй эсвэл хар амиа бодсон хэдхэн улс төрчдийн гайгаар, үнэ өөрчлөгдөхгүй гэсэн хуурамч хүлээлт иргэдэд бий болов. Улмаар барааны хомсдол үүсч, улс төрчдийн нэр хүнд цойлж, улс орон харин уруудах болов.

Засгийн газар шатахууны хилийн үнэ өндөр байхад онцгой татвараа багасгаж, буурахаар нь өсгөх замаар 2008 оноос үнийг харьцангуй бага өөрчлөлттэй зохицуулж ирсэн. Харин 2017 оноос гадаад, дотоод өрөндөө баригдаад, төсвийн орлогынхоо дөрөвний нэгийг зээлийнхээ зөвхөн хүүд өгөхөд хүрсэн учир гаднаас тусламж, хандив гуйж, ОУВС-аас хөнгөлөлттэй зээл дахиад авав.

Тэгэхдээ ОУВС-ийн шаардлага нэрээр Засгийн газар олон төрлийн татвар нэмсний нэг нь шатахууны онцгой татвар байв. Шатахууны импортын үнэ

өсөлттэй байсан ч, онцгой татвараа 2017 оны 7, 11-р саруудад хоёр удаа нэмсэн нь шатахуун түгээгч компаниудыг алдагдалд оруулж, эцэст нь үнээ нэмэхэд хүргээд байна. Эс нэмбэл шатахууны хомсдол нүүрлэх гэж байна.



ХЯЗГААРЛАСАН ҮНЭ ХОМСДОЛ, ДАМПУУРАЛ АВЧИРДАГ

Үнийг төр засаг, аль нэг байгууллагын тушаалаар тогтоох оролдлого эцсийн дүндээ тухайн барааг хомсдоход л хүргэдэг. Учир нь аливаа барааны эрэлт, нийлүүлэлт маш олон хүчин зүйлээс хамааран үргэлж өөрчлөгдөж, тэр өөрчлөлтийг зөвхөн чөлөөт үнэ л зөв зохицуулж зах зээлийн хэвийн ажиллагааг хангадаг. Энэ бол тухайн бараа ховордохоор үнэ нэмэгдэж, элбэг болохоор үнэ буурдаг зах зээлийн алтан дүрэм. Энэ дүрмийг зөрчвөл удалгүй хомсдол, дараа нь дампуурал ирдэг.

Үнэ гэдэг мэдээллээр дамжуулан үйлдвэрлэгч, нийлүүлэгч болон хэрэглэгч нар хэрэглээ, бизнесээ зохицуулсны үр дүнд эрэлт, нийлүүлэлт харилцан тэнцвэртэй байж, эдийн засаг бүхэлдээ хэвийн өрнөдөг. Гэхдээ энэ тэнцвэр их багаар алдагдах бүрт үнэ өөрчлөгдөн буцааж тэнцүүлдэг. Харин төр засаг үнийг хүчээр тогтоосноор тэнцвэр тодорхой хугацааны дараа огцом алдагдаж хомсдол, хямралд шууд ордог.

Энэ бүхнийг монголын төрөөс цахилгаан эрчим хүч, түлш гэх өргөн хэрэглээний олон барааны үнийг зохицуулахыг оролдож, хөгжлийг чөдөрлөж буйгаас харж болно. Жишээ нь түлш шатахууны үнийг яаж бүрдүүлж буйг харъя. Монгол улс экспортоор олсон валютынхаа тавны нэгээр эргүүлээд түлш шатахуун импортлож, шатаадаг эдийн засагтай орон. Манай шатахууны хангамж Орос улсаас бүрэн хамаардаг. Хойд хилээр шатахууныг Оросын нэг компани Сингапурын зах зээлийн үнээр нийлүүлдэг.

ЧӨЛӨӨТ ҮНЭ СОНГОЛТ, ХӨГЖИЛ АВЧИРДАГ

Морио унахаасаа өмнө бүгдээрээ ер нь үнийг төр зохицуулахгүй бол яадаг, юу болохыг, яагаад үнийг төр засаг биш иргэд өөрсдөө тогтоох нь ашигтай болохыг ярилцъя.

Хэрэв үнийг төр зохицуулдаггүй байсан бол “Үнийн зөвлөл” гэгч төр засаг, компани, үйлдвэрчний төлөөлөл хамтарсан хуурамч жүжиг тавих шаардлагагүй юм. Энэ гурав дотор хэрэглэгчийн төлөөлөл байхгүй учир зах зээлийн хүч чадал алга. Харин чөлөөт зах зээл дээр хэрэглэгчид аль хямдаас нь өөрөө сонгоно. Манай шатахуун нийлүүлэгчид гадаад үнэд нөлөөлж чадахгүй учир жижиглэнгийн үнээ болон үйл ажиллагааны зардлаа бууруулахын төлөө өрсөлдөх болно. Энэ чөлөөт өрсөлдөөн л үнийг бууруулдаг. Хэрэв шатахуун түгээгч компаниуд үгсэн хуйвалдаж, үнэ ижил түвшинд барих юм бол тэр компанийг өндөр дүнгээр торгох, бүр зөвшөөрлийг нь хурааж авах хүртэл шийтгэж болно. Гэхдээ хууль журмын дагуу.

2018 оны 1-р сарын байдлаар А-92 бензиний хил дээрх үнэ нэг литр нь 1630 төгрөг, дээр нь татварт 512 төгрөг [гаалийн татварт 5 хувь буюу 81 төг, замын сангийн албан татварт 25 төг, онцгой албан татвар 210, НӨАТ 195 төг] буюу 30 хувь, төмөр замын тээвэрт 16 төгрөг төлж, нийт өртөг нь 1661 төгрөг болсон ч, 1620 төгрөгөөр борлуулж байна. Гэтэл үйл ажиллагааны ямар ч зардал ороогүй байхад 41 төгрөгийн алдагдалтай байна. Энэ тохиолдолд компаниуд эсвэл борлуулалтаа зогсооно, эсвэл дампуурна. Аль ч тохиолдолд, үнэ тогтоосон түшмэдээс хэн нь ч хариуцлага хүлээхгүй, хэрэглэгчид л харин хохирно.

Шатахуун импортлогч компаниуд энэхүү “зохицуулсан” үнээр гурван сар явж, төр онцгой татвараа бууруулахыг хүлээсэн ч тусыг эс олсон учир үнээ нэмэхээс өөр сонголтгүй болжээ. “Үнийн Зөвлөл” гэгч гаж зуршилтай газар асуудлыг яаж шийдэхээ мэдэхээ байжээ. Засгийн газар нь татвараа нэмж, ашгаа авчихаад, бүх бурууг компаниудад тохож “нэр хүндээ” хамгаалж эхэлжээ. Монгол улсад бензин, түлшний хомсдол нүүрлэж эхэллээ. Үнэ тогтворжуулах Монголбанкны ээлжит үлгэр ийнхүү жаргав.

Шатахуун тасалдвал нийслэлд машин багасч, морь олшрох бөгөөд дугаарын хязгаарлалт хийх боломжгүй учир замын түгжрэл багасч, агаарын бохирдол буурах байх даа.

Чөлөөт үнэ бол хэрэгцээг зохистой болгож, шинэ хэрэглээг урамшуулдаг чадвартай. Бензиний үнэ өсөхөөр хэрэглэгчид машинаа бага хэрэглэж, нийтийн тээвэр ашиглахыг эрмэлзэх учраас нийтийн тээврийг сайжруулах, чиглэлийг нь олшруулж, хуваарийг нь зохистой болгохыг шаардаж эхэлнэ. Машины тоо цөөрч, замын түгжрэл багасч, агаарын бохирдол буурна.

Түлшээр халаадаг байр саваа нар салхины эрчим хүчийг ашиглах, байшингийн дээврээ нарны зайн хураагууртай болгох, яваандаа цахилгаан машинтай болохыг зорино. Гэх мэтээр хэрэглээний бүтэц өөрчлөгдөж шатахууны хэрэгцээ багассанаар үнэ буурахаас өөр сонголтгүй болдог. Энэ бол хэрэглэгч үнэ тогтоож байгаа хэрэг юм.

Засаг үнэ хязгаарлахаа зогсоож, онцгой татвараа цуцлах аваас шатахууны үнэ 30 хувиар буурах юм.

2018.01.17



Б.ГЭРЭЛМАА

АНУ-д бүртгэлтэй Steppe компанийн үүсгэн байгуулагч

ДеФакто **ЯРИЛЦЛАГА**

Монгол, англи, орос хэл дээрх ярилцлага, <http://jargaldefacto.com/category/8>

БЛОКЧЕЙН ТЕХНОЛОГИ НЬ ДЭЛХИЙ ДАЯАР ТАРХСАН, ХАМГИЙН ӨНДӨР НУУЦЛАЛТАЙ, ХАМГИЙН ИХ ИТГЭЖ БОЛОХ ДЭД БҮТЦИЙН ТЕХНОЛОГИ ЮМ

Батчулууны Гэрэлмаа нь Солонгосын Шинжлэх Ухаан Технологийн ахисан судалгааны институтыг Санхүүгийн математик ба Менежментийн давхар мэргэжлээр төгссөн. Магистрын зэргээ Франц дахь Версалийн их сургуульд Эко-Инновацийн менежментийн чиглэлээр хамгаалсан. Суралцаж байхаасаа эхлэн тогтвортой хөгжил, эдийн засгийн бодлого, санхүү, инноваци болон корпорацийн засаглалын төслүүд дээр ажиллаж байсан. Steppe компаниа 2015 онд АНУ-д үүсгэн байгуулж үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд Блокчейн гэх шинэ технологийг монголд нэвтрүүлэхээр ажиллаж эхэлжээ.

Д.Ж: Сайн байна уу та. Steppe компаниа товч танилцуулна уу.

Б.Г: Би АНУ-ын Нью-Йоркийн Манхаттанд куант буюу тооцооллын аналитаар ажиллах зорилгоор очиж байсан. Тэгтэл бусдын л хийдэг ажилтай адилхан, онцгойрох зүйлгүй мэт санагдаж эхэлсэн учраас энэ миний насан туршдаа хийх зүйл мөн үү гэж өөрөөсөө асуухад хүрсэн. Тэгээд эргэн тойронд маань хүмүүс start up бизнест орох нь ихэж байсан учраас надаас бизнесийн зөвлөгөө авах эрэлт их байгааг ажиглаад Австрали гаралтай Америк найзтайгаа хамтраад Steppe компанийг байгуулсан юм. Анх шинээр гарч ирж байгаа зах зээлүүдэд судалгаа хийж, стратегийн зөвлөгөө өгөхөөр байгуулсан. Мөн би Монгол хүн учраас бренд маягаар тал нутаг гэсэн утгатай Steppe гэдэг нэрийг өгсөн.

Д.Ж: Шинээр гарч ирж байгаа бизнесүүдэд зах зээлийн, тэр дундаа инновацийн чиглэлээр зөвлөгөө өгдөг байх нь. Та монголд юу хийе гэж бодож байгаа вэ?

Б.Г: Манай үндсэн үйл ажиллагаа энгийн консалтинг компаниудаас арай өөр. Энгийн консалтинг компаниуд инженерийн шийдэл юм уу статистик дээр тулгуурласан хамгийн эцсийн бүтээгдэхүүн нь нэг презентаци юм уу, тайлан болоод дуусдаг. Харин манай компани хэрэгтэй гэж үзвэл Prototype буюу ажиллаж байгаа загвар болон системийн дизайныг нь гаргаж, шийдэл процессыг нь хэлж өгдөг. Манай компанийн хамгийн гол онцгойрох зүйл нь "integrated innovation" буюу нийлмэл шинэчлэл. Мэдээж Америк бол асар том зах зээл, тэнд аль хэдийн байр сууриа олчихсон ижил төрлийн үйлчилгээ эрхэлдэг компаниудын үйлчлүүлэгчдийг булаах нь их хэцүү. Тиймээс бид анхны үйлчлүүлэгчдээ холбоо харилцаагаа ашиглан олж байсан. Бид IBM Tokyo, Harvard, Stanford, MIT болон Berkeley зэрэг сургуулиудтай судалгааны түвшинд хамтарч ажилладаг. Ерөнхийдөө улсуудын бодлогын хүрээнд ямар хэмжээний систем гаргаж ирэх үү, ямар инженерчлэл явах уу гэдэг дээр дизайны өөрчлөлтийн аргууд боловсруулдаг.

Д.Ж: Энэ Блокчейн гэдэг технологи яагаад маш чухал юм бэ гэдгийг та тайлбарлаж өгөөч?

Б.Г: Блокчейн бол интернетийн дараах хувьсгал

болоод гараад ирлээ. Блокчейн нь хоёр үндсэн гол санааг нэгтгэсэн технологи юм. Эхнийх нь "тархалттай бүртгэлийн систем"-тэй буюу хамгийн аюулгүй. Хоёрдугаарт тархалттай бүртгэлийн систем нь "hash алгоритм" гэдэг зүйлээр ажилладаг. "Hash алгоритм" гэдэг нь нэг чигийн математикийн функц ба энэ нь дурын мэдээллийг оруулаад гаргахад яг адилхан 256 битийн хэмжээтэй код болгоод гаргаад ирдэг. Энэ нь дахин давтагдашгүй, аюулгүй бөгөөд дэлхий даяар тархсан блок гэж нэрлэгдээд байгаа CPU нь бүртгээд авчихсан байна гэсэн үг.

Д.Ж: CPU гэж юу билээ? Өмнө нь байсан биш билүү?

Б.Г: CPU нь Control Processing Unit-ын товчилсон нэр. Урьд нь IP-г хакердахад амархан байсан ба CPU-г хакердахад түүнээс 100 дахин хурдтай компьютер хэрэгтэй. IP-ээр дамждаг байсныг CPU рүү шилжүүлж байна гэсэн үг.

Д.Ж: Ямар ч хэмжээний мэдээлэл оруулахад "Hash алгоритм"-аар код болж гарч ирнэ гэлээ. Энэ кодыг гаднаас нь хараад ямар мэдээлэл байгаа гэдгийг нь таамаглах боломжгүй, хакердах гэвэл маш өндөр хурдтай компьютер хэрэгтэй байх нь. Тийм үү?

Б.Г: Мэдээллийг хувиргасан кодыг дэлхий даяар байгаа блокуудад түгээхэд 10 минут зарцуулагддаг бөгөөд тэр хооронд амжиж хакердах боломж бий. Гэвч тэгэхийн тулд одоогийн байгаа Google-ийн компьютероос 100 дахин хурдтай куант компьютерууд гарч ирж байж хакердана. Харин куант компьютерууд гарч ирэх үед Блокчейний дараагийн IOTA буюу Tangle гэх төрлийн Блокчейн хөгжсөн байх учраас куант компьютероос ч хакердах боломжгүй.

Д.Ж: Энэ технологи нь амьдралын практикт ямар хэрэгтэй юм бэ?

Б.Г: Хоёр хүн хоорондоо нийгмийн харилцаанд ороход гуравдагч хүн нь зохицуулагчаар оролцдог байгаад удаж байна. Жишээ нь засгийн газар, төв банк, шүүх байгууллага гэх мэт. Тэгвэл үүнийг алга болгох буюу хоёр хүн хоорондоо шууд үнэнээр ярилцдаг систем бий болгох санаагаар энэ технологи анх үүссэн. Бид бүх мэдээллээ төвлөрсөн нэг газар байлгахад авлигаар ч юмуу ямар нэгэн аргаар мэдээллийг өөрчлөх гэх мэт буруу сэдлүүд их үүсээд байдаг байна.

Д.Ж: Энэ технологийн хамгийн давуу тал нь мэдээллийг өөрөө батлах боломжтой болсноороо үйлдэл хийх хугацааг маш богино болгож байна.

Б.Г: Блокчейн технологи нь дэлхий даяар тархсан, хамгийн өндөр нууцлалтай, хамгийн их итгэж болох дэд бүтцийн технологи юм. Блокчейн технологи дээр суурилсан хамгийн анхны хэрэглээ нь санхүүгийн салбар руу орсон буюу Биткойн.

Д.Ж: Блокчейн технологийг нийгэмд яаж ашиглах вэ? Жишээ нь тендер зарлах, сонгуулийн үед?

Б.Г: Ийм жишээ бусад улсуудад аль хэдийн хэрэгжиж эхэлсэн байгаа. Эстони улс гэхэд 1996 оноос хойш цахим засаглалд шилжиж орсон ч төвлөрсөн байсан учраас замдаа хакердуулсан. Ингээд улсаараа хакердууллаа яах вэ гээд байж байтал 2008 онд Блокчейн технологи гарч ирэхэд үүнийг л бид ашиглах ёстой юм байна гээд сонгосон. Одоо "Блокчейн nation" болчихсон байгаа. Тэд цахим засаглал буюу сонгууль өгөх, татварын буцаан олголт зэрэг бүх зүйлдээ Блокчейн технологийг ашиглаж байна. Монголчуудын хувьд сонгуулийн хар хайрцаг нь софтвер систем нь цаанаасаа суучихсан ирдэг буюу хакердах боломжтой гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл төвлөрсөн системтэй гэсэн үг л дээ. Хэрвээ бид Блокчейн технологиор саналаа өгөх юм бол миний цахим дугаар, санал хэзээ ч өөрчлөгдөх боломжгүй учраас хамгийн шударга сонгууль болно гэсэн үг.

Д.Ж: Эстонид очиж үзэхэд хүмүүс сонгуулиа гар утсаараа өгч байсан. Санал луйвардах боломж байхгүй юу гэхэд ямар ч боломж байхгүй гэж хэлж байсан. Мөн сонгуулийн хянагч, төсөв төлөвлөгөө гээд манайд их хөрөнгө зарж зохион байгуулдаг ямар ч зүйл Эстонид байгаагүй. Технологийн хөгжил улс орнуудад түүхэндээ байгаагүй гайхамшигтай боломжийг өгч байна. Үүнийг ашиглахын тулд бид яах ёстой вэ?

Б.Г: Хувьсгалын тохиргоо бүрдэнэ гэдэг шиг Блокчейн технологийг авч ашиглаад нийгэм, эдийн засаг, засаглалаа сайжруулаад илүү зардлаа (тухайлбал сонгуулийн зардал) танаад хэрэгтэй зүйлдээ зарцуулах боломж байна. Эстони 1,5 сая хүн амтай, асар хурдан энэ технологийг нэвтрүүлж чадсан.

Д.Ж: Эстонид энэ технологийг нэвтрүүлснээр хахууль үгүй болсон байна лээ. Америк шиг том улсад хэрэгжүүлэхэд их том бүтэцтэй учраас удаан хугацаа шаардана, харин манайх шиг жижиг зах зээлтэй оронд илүү хурдан хэрэгжих боломжтой.

Б.Г: Ихэнх хүмүүс жижиг зах зээлээ сул тал гэж боддог ч нөгөө талаасаа энэ нь өөрчлөхөд амар, илүү өгөөжтэй. Нэг ийм үг байдаг "Туршилт хийж байгаа бол маш хямдхан, хурднаар үзээд алд, болохгүй бол дараагийн алхамдаа ор" гэж. Монголд тохироо нь яг бүрдсэн байгаа. Нөгөө талаасаа Блокчейн технологийг Орос, Хятад гэх мэт орнууд нэвтрүүлэхээр ярьж эхэлсэн бол бусад том орнууд үүнийг

заналхийлэл байдлаар хүлээж авах магадлалтай байхад Монголд нэвтрүүлэе гэвэл Цахиурын хөндийгөөс туслахдаа таатай байх жишээний.

Д.Ж: Тусламж авахаас гадна их сургуулийн хүүхдүүддээ зааж өгвөл тэд мэдээллээ дэлхий рүү экспортолох боломжтой болно, тийм үү?

Б.Г: Манай компани Монгол улсыг Блокчейн технологийг ашиглаад цаашдаа хаашаа явах санааг эхний байдлаар гурван хугацаанд гаргасан байгаа (богино, дунд болон урт хугацаанд) бөгөөд одоохондоо арай төгс болоогүй байгаа учраас олон нийтэд үзүүлээгүй байна. Түүнд боловсролын салбар, мөнгөний бодлого, хууль эрх зүйн орчин зэрэгт яаж ажиллах тухай тодорхой тусгаж өгсөн байгаа. Хэрвээ бид үнэхээр "Крипто nation" болохыг хүсч байгаа бол таны хэлсэнчлэн боловсролын системдээ оруулаад төрөлжүүлсэн сургалтыг нь явуулж чадах юм бол гэрээсээ ажилладаг олон улсын ажил хийгээд ч амьдрах боломжтой.

Д.Ж: Үүнийг сургуульд заахад хэдэн жил хэрэгтэй вэ?

Б.Г: Тэгж их удахгүй. Дэлхийн бүх тэргүүлэх сургуулиуд жишээ нь Princeton-ий их сургуульд Блокчейн технологийн бүтэн курс гараад ирсэн байгаа. Компьютерийн шинжлэх ухаанаар сурдаг оюутнууд нь нэг семестертээ авдаг ч юмуу. Мөн дурын мэдээллийн технологийн мэргэжилтэн хэрвээ хүсэх юм бол сурах боломжтой. Учир нь нээлттэй тавигдчихсан байгаа. Би монголын мэдээллийн технологийн салбарт ажилладаг залуусыг чадвартай гэж үздэг. Тэгэхээр хамгийн түрүүнд боловсролоос эхлэх хэрэгтэй.

Д.Ж: Эрүүл мэнд, даатгал, нэрийн данс, хүүхдийн бүртгэл гэх мэтийг крипто маягт шилжүүлэх боломж гарч иржээ. Бүтээлч устгал буюу хуучирч байгаа зүйлсээ шинэ технологиор орлуулж ажиллах боломж бүрджээ.

Б.Г: Тэгэхийн тулд түвшин бүртээ зөв мэдээлэл олж авах хэрэгтэй байна. Үүнийг ашиглаад шинэчлэл явагдаж болох юм байна гэдгийг ойлгож байгаа ч, яаж хийх үү гэдгээ мэдэхгүй байна. 2018 оноос манай компани <http://www.steppe.in/> вебсайт дээрээ дэлгэрэнгүй мэдээлэл оруулах ажил төлөвлөсөн байгаа.

Д.Ж: Яагаад <http://www.steppe.in/> буюу IN төгсгөлтэй байгаа юм бэ?

Б.Г: Сүүлийн үед технологийн салбарт шинэ домайн нээх тренд үүсээд байгаа. Америкт Steppe гэдэг нэрийг аль хэзээний авсан байсан учраас IN гэдэг төгсгөлтэй вебсайтаа нээсэн. Хэрвээ давхардсан PE-г нь анзаарахгүй харах юм бол "step in" буюу "Алхаад орох" гэсэн утгатай.

2017.12.09

Дефакто ярилцлагын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв.

Ярилцлагын бүрэн эхийг <http://jargaldefacto.com/article/b-gerelmaa-gerelmaa-batchuluun> холбоосоор үзнэ үү.

Татгалзахын аргагүй САНАЛ

FORD EXPLORER | RANGE ROVER | JAGUAR F-PACE

ШАТАХУУНЫ ЭРХ | ӨВЛИЙН ДУГУЙ

АЯЛАЛЫН ЭРХ | СЕРВИС ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРХ

Холбоо барих: 99118301, 99106507, 99118375
www.waa.mn

WAGNER ASIA AUTOMOTIVE LLC



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 19 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл: 2018.01.14-ний дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://fargaldefacto.com/category/12>

УУХУЯ-НЫ ЗӨРЧИЛ



Уул уурхай хүнд үйлдвэрийн дэд сайд Д.Загджав Оюу толгой ХХК-ийн үйл ажиллагааг зогсоох ёстой гэж байр сууриа илэрхийлснийг сайд Д.Сумъяабазар үгүйсгэж энэ бол яамны байр суурь биш бөгөөд хэрэв Д.Загджавыг дахин ийм асуудал гаргавал эргүүлэн татах тухай ярина гэсэн. Мөн сайд Д.Сумъяабазар Оюу толгойн ТУЗ-ийн гишүүд үлбэгэр, муу ажиллаж байна гээд Оюу толгойд худалдагдсан олон хүмүүс мэдээлэл алдагдуулж байна гэжээ.

Энэ үйл явдалд МУ-ын ЗГ-ын дэд сайдын албан тушаал, Оюу толгой гэсэн хоёр асуудал хөндөгдөж байна. Эхний асуудал болох дэд сайдын албан тушаалыг нэг хэсэг шаардлагагүй орон тоо гэж үздэг байсан. Төрийн нарийн бичгийн дарга нь улс төрийн албан тушаал биш учраас сайд нь солигдсон ч яамны үйл ажиллагааг аваад явна хэмээн үздэг байв. Тэгсэн ч ЗГ солигдох үедээ төрийн нарийн бичгийг ч, дэд сайдыг ч мөн сольж байгаа. Гэвч нам дотор өөрчлөлт орох үед бол сольдоггүй ба учир нь дэд сайд гэдэг албан тушаал намдаа онцгой их хандив өргөсөн, мэдлэг чадвар нь сайд болох хэмжээнд арай ч биш, сулавтар, туршлага бага хүмүүсийн буюу хандив өргөгчдийн төлбөрийн албан тушаал гэж харж байгаа. Өнгөрөгч долоо хоногт Д.Сумъяабазар сайдтай **ярилцлага** хийхэд тэрээр “яамны байр суурийг сайд нь илэрхийлж байх ёстой ба дэд сайд бол дэд сайд, өгсөн үүрэг даалгаврын дагуу л ажилладаг, болохгүй бол хариуцлага тооцдог” гэж хэлсэн. Ингээд энэ ярилцлага ба бусад олон үйл явдлаас харахад дэд сайд гэдэг албан

тушаал нь улс төрийн намуудын санхүүжилттэй холбоотой албан тушаал байгаа юм. МУ-ын төрийн албан тушаалуудыг улс төрийн намууд ийнхүү бараа болгож байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Оюу толгойг стратегийн орд гэх нэрийдлээр 34 хувийг ЗГ эзэмших болсноос хойш хяналт тогтоох оролдлого байтугай, МУ-д ашиг хүртээх бус харин ч өрөнд оруулж байгаа. Оюу толгойн хувьд Д.Сумъяабазар сайдын хэлснээр цаанаасаа 3-4 хувийн хүүтэй авсан зээлийг МУ-ын ЗГ-ын 34 хувьд тооцохдоо 6 хагас буюу 3 хувиар нэмж хүү тооцож байгаа гэсэн. Мөн ТУЗ-ийн томилсон гишүүд нь үлбэгэр байна гэж хэлсэн ба Ерөнхийлөгч саяхан энэ хүмүүсийг солих тухай ярьсан. ТУЗ-ийн дарга нарыг томилохдоо тодорхой ажил үүргийн мэдлэг чадварыг тавих хэрэгтэй. Бид тодорхой шалгуураар томилоогүй юм чинь юугаар нь шалгах вэ дээ. Оюу толгойтой холбоотой гарч ирдэг дараагийн асуудал нь Дубайн гэрээ. Далд уурхайн бүтээн байгуулалтын төлөвлөгөөнд гарын үсэг зурж энэхүү гэрээг байгуулснаар Оюу толгойн төсөл урагшилсан. Гэхдээ хувьцаа эзэмшигчид шийдвэрлээгүй байхад нь далд уурхайн бүтээн байгуулалтуудыг санхүүжүүлэх үндсэн зарчмуудыг баталсан гэж буруутгадаг. Монголын ЗГ, Оюу толгой хооронд байсан гол асуудал нь 4.7 тэрбум долларын зардлыг манайх хүлээн зөвшөөрөхгүй байсан юм. Оюу толгойн бүх нөөцийн 70 гаруй хувь нь газар доор буюу 1 км-ээс доош байгаа. Дээр байгаа 30 хувийг нь амжилттай олборлож байгаа. Тэр доор байгаа нөөц рүү орохын тулд мэдээж их хэмжээний мөнгө шаардлагатай байсан ба түүнийг барих босгох 4.7 тэрбум долларын зардлаас 1 тэрбум гаруйг нь Монгол хүлээн зөвшөөрөхгүй байсан юм. Үүнийг Ч.Сайханбилэгийн ЗГ зөвшөөрч, энэхүү ажлыг хийсэн л дээ. Нэг талаас улс төрчид Оюу толгойг өөр өөрийн өнцгөөс харж ялгарахыг хичээдэг. Гэрээг байгуулснаар Оюу толгойн төсөл хөдөлснийг тэмдэглэх хэрэгтэй. Гагцхүү гэрээнд өөрчлөх зүйлс байгаа юу гэвэл байгаа.

БАНКУУДЫН АКТИВЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ



2016 онд ОУВС-ийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн нэг нөхцөл болж тусгагдсанаар банкуудын активын чанарын үнэлгээг хийсэн. Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайханы мэдэгдсэнээр банкуудад хийсэн активын чанарын үнэлгээгээр ямар нэгэн эрсдэлтэй

зүйл гараагүй гэнэ. Мөн Н.Баяртсайхан энэ үнэлгээнд тохируулга хийж байна гэж мэдэгдсэн.

Үүнд би 3 дүгнэлт хийе. Активын чанарын 2016 оны үнэлгээг 2017 онд тохируулга хийгээд хөндлөнгийн аудит хийлгэнэ гэж хэлсэн. Олон улсын ЗА зэрэглэлийн компаниуд монголын бүх арилжааны банкуудын активыг буюу түүний ангиллыг судалж үзсэн том шалгалт болсон. Энэ шалгалтын эцсийн үр дүн одоогоор нууц хэвээр байгаа. Анх удаа Монголбанкны Ерөнхийлөгч тайлбар хийсэн. Гэхдээ тайлбар нь тодорхой биш мэдээлэл байсан. Үнэхээр эрсдэлгүй юм бол ил тод хэлчих ёстой шүү дээ. Тохируулга гэдэг нь 2016 оны активын үнэлгээний байдлыг 2017 он гээд бүтэн санхүүгийн жил өнгөрсөн байгаа тул тэр санхүүгийн жилийн баланс дээр байгаа үзүүлэлтүүдтэй

харьцуулж үзээд эрсдэлгүй байгаа эсэхийг шалгаж байгаа байх гэж ойлгож байна. Монголбанк бас өөрсдөө 2017 оны үнэлгээг нь тэр аргачлалаар нь хийнэ гэж ойлгосон.

Арилжааны банкуудаар өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх бизнес төлөвлөгөө гаргуулна гэж хэлсэн. Тэгээд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх 6 сарын хугацаа өгөх бөгөөд энэ хугацаанд амжихгүй бол дахин хөрөнгөжүүлэх асуудал гарна гэсэн байгаа юм. Арилжааны банкуудыг дахин хөрөнгөжүүлэх хэмжээнд өөрсдөө байна уу, гаднаас байна уу, хөрөнгийнх нь чадварыг нэмэгдүүлэх хэмжээний шаардлага бий болсон гэж ойлгож байна. Монголбанк үүний дараа стресс тест хийнэ гэж хэлсэн. Стресс тест хийнэ гэж санхүүгийн хэллэгээр бол санхүүгийн байгууллагуудыг тодорхой хямрал болвол яаж давж чадах вэ гэдгийг шалгадаг аргачлалыг хэлдэг. Жишээлбэл ДНБ өсөхгүй унах, төгрөгийн ханш унах, ажилгүйдэл эрс нэмэгдэх гэх мэт макро эдийн засгийн тодорхой хямралын нөхцөлд тухайн банкуудын баланс дахь зээлийн ангиллууд муудах хандлага гардаг ба аль зэрэг хэмжээнд муудахад нь тэр банк даах вэ гэдгийг шалгадаг. Хямрал болоогүй үед нь банкууд бэлэн эсэхийг мэдэх шинэ ажил хийж байна гэж харж байна.

Төв банкны хууль саяхан батлагдлаа. Хуучин бол төв банкны ерөнхийлөгч ганцаараа шийдвэр гаргаж, мөнгөний зөвлөхүүд зөвхөн зөвлөх эрхтэй оролцдог байсан бол одоо үүнийг хамтын шийдвэр болгоно гэж яригдаж байна. Мөн хуучин Монголбанк зөвхөн инфляцийг онилдог байсан бол гадаад худалдаа, мөнгөний харьцаа зэргийг

онилно гэж ярьж байна. Тийм төв банкууд дэлхий дээр байгаа буюу жишээ нь Энэтхэгийн төв банк байдаг. Гэвч Энэтхэгийн төв банк жишээ нь гадаадаас мөнгө ирвэл төв банкинд хадгална гэсэн заалтууд байдаг ба ийм болохгүй байх гэж найдаж байна. Мөн шинэ хуулинд “Банкны тогтворжуулалтын сан” байгуулж байгаа. Хадгаламжийн 1.3 хувьтай тэнцэх дүнг төв банк өөр дээрээ байгуулж, албан ёсоор авна. Ингэснээр системийн тогтвортой байдлыг хангана гэж байгаа ч энэ нь тийм ч тодорхой биш л дээ. Юу тодорхой вэ гэвэл банкны зардал нэмэгдэж байгаа нь л тодорхой. Хадгаламжийн 1.3 хувь нь явчих юм бол зээлийн хүү нэмэгдэх эрсдэлтэй гэсэн үг. Үүний зэрэгцээ хадгаламжийн даатгалын тогтолцоо гэж хууль гарснаар “Хадгаламжийн даатгалын корпораци” байгуулсан. 20 сая хүртэлх таны хадгаламжийг банк дампуурсан ч гаргаж өгнө гэж баталгаажуулан, банкууд үүнд хураамж төлдөг ба хадгаламжийнхаа 0.125-тай тэнцэх хураамжийг улирал тутамд төлдөг тогтолцоо байгаа. Энэ олон сангууд нийлээд банкны зардлыг нэмэгдүүлж байгаа юм. Н.Баярсайхан дөнгөж Монголбанкны Ерөнхийлөгчөөр томилогдсоны дараа Монголбанкны нөөц байхгүй байна гэж хэлсэн. Хэдий ингэж хэлсэн нь үнэн байсан ч улс төрчид их шүүмжилсэн. Үүнийхээ дараа активын чанарын үнэлгээгээр энэ салбарт эрсдэл байхгүй байна гэж хэлж байна. Эрсдэл байхгүй байсан бол яагаад энэ олон арга хэмжээг авч, хууль дүрмээ чангатгаж байгаа юм бэ. Эрсдэл мэдээж байгаа.

ДУЛААНЫ V ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСЛИЙГ ЗОГСООЛОО

2011 онд эхлүүлсэн дулааны V цахилгаан станц төслийг зогсоосон гэдгээ Эрчим хүчний яам мэдэгдлээ. Уг нь 450 мвт-ийн хүчин чадалтай станц барихаар төлөвлөж байсан. Энэ төслийг зогсоогоод одоо байгаа станцуудын хүчин чадлаа нэмэгдүүлэх, сэргээн засах ажлыг хийхээр болжээ.

20 гаруй жил ярьж, 10 удаа шавыг нь тавьсан төсөл л дөө. 5-р цахилгаан станцыг барина гэсэн компаниуд дотор Францын Энжие гэдэг дэлхийн хамгийн том дэд бүтцийн компани байсан. Японы дээрээсээ 3 дахь том худалдааны компани болох Сожиц корпораци, Солонгосын Поско Энержи гэсэн гангийн үйлдвэрээр дэлхийд ноёлж байгаа компани ба монголын НьюКом компаниудын олон жилийн хөдөлмөрийг хийсгэсэн явдал болж байна. Энэ бүхний цаана цагийн хүчин зүйл гэж байдаг ба хэрвээ бид төслийг эхэлмэгцээ хийсэн бол энэ мөнгө босчих байсан юм. Дээр дурдсан компаниуд мөнгөө босгочихсон байсан. Харин одоо бид хүсээд, уйлаад яасан ч цахилгаан станц барих мөнгө дэлхийн зах зээл дээрээс босгохгүй.

Ганцхан энэ төслийг ч бус Сайншандын аж үйлдвэрийн паркийг мөн зогсоож байгаа шүү дээ. Засгийн газар нь ийм болохоор МУ-ын хувийн салбарт гадаадынхан итгэхгүй байгаа юм. Төр засгийнх нь зээлжих чадвар унаад ирэхээр монголын хувийн компани яаж ч сайн ажиллаж байсан гадаадын хөрөнгө оруулагчид үл ойшооно. Дэлхий дээр Парисын гэрээ, тогтвортой хөгжлийн хөтөлбөр гэх мэт карбоныг хязгаарласан олон гэрээнүүд гараад компаниудыг ялангуяа томоохон банкуудыг буюу ЗА зэрэглэлийн банкууд 30-40 жилийн том төслүүдийг санхүүжүүлдэг ч энэ банкууд одоо мөнгө өгөхгүй.

Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв.

Тоймын бүрэн эхийг <http://jargaldefacto.com/article/defakto-toim-2sh18-sh1-14> холбоосоор үзнэ үү



NEW NISSAN PATROL

☎ 9911-0014, 9911-5140, 9910-0167

ЛИЗИНГИЙН НӨХЦӨЛ:

Урьдчилгаа **0%**

Хүү **1.4%**

Хугацаа **84** сар

УРАМШУУЛАЛ:

-  Хамгаалтын хууца
-  Сэлбэг сервисын эрх
-  4u Өвлийн дугуй
-  Салманы шигшнэй хамгаалалт

ҮНЭ: ₮214.0 сая



JARGAL DEFACTO

ГАР УТАСНЫ АППЛИКЭЙШН

Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол төлбөргүй хүлээн авахыг хүсвэл www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Дамбадаржаагийн Жаргалсайхан
Дангаасүрэнгийн Энхбат

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Ерөнхий редактор: Ганбаатарын Жавзмаа
Баг: Батхүүгийн Амар
Отгонсүрэнгийн Билгүүн
Өсөхбаярын Биндэръяа
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com
✆ +976 94109342
🌐 www.defacto.mn